

Дундговь аймгийн Засаг дарга, Барилга хот байгуулалтын сайдтай 2022 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2022.12.12


Аймгийн Засаг даргын Барилга, хот байгуулалтын сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн явцад эхний хагас жилийн хяналт-шинжилгээг хийж, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажиллан өгсөн зөвлөмжийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулж жилийн эцсийн тайланг ирүүлсэн.

НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын Барилга хот байгуулалтын сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2 -т заасан арга зүйгээр Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 100 үүргийг хүлээж жилийн эцсийн байдлаар 98.1 хувьтай хэрэгжүүлсэн нь эхний хагас жилийн хэрэгжилтээс 10.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 100 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 94 арга хэмжээ 100 хувь, 3 арга хэмжээ 90 хувьтай, 2 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 0 хувьтай байна.



ХОЁР. ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ГЭЖ ҮЗЭВ.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хүрээнд:

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн I3713-мон төсөл”-ийн хүрээнд аймгийн төвд хоногт 3000м³ хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж болон гэр хорооллын 5,57 км ариутгах татуургын шугам сүлжээний барилга угсралтын ажил мөн Эрдэнэдалай сумын 50м³/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ариутгах



Адаацаг, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Сайхан-Овоо, Цагаандэлгэр сумдын газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах ажлыг хийлгэхээр ОНХСангийн хөрөнгөд 72.0 сая төгрөгийн төсвийг батлуулсан.

Адаацаг 548, Дэлгэрцогт 405, Цагаандэлгэр 575, Эрдэнэдалай 637, Сайхан-Овоо 486, Дэлгэрхангай 606 нийт 3257 газар зүйн нэр 2004 онд Улсын Их Хурлаар батлагдсан байсныг уг ажлын хүрээнд 4245 болж шинээр тодруулсан 988 газар зүйн нэрийн хувийн хэрэг хөтөлж, УИХ-аар батлуулах хүсэлтийн маягтыг бэлэн болгоод байна. Сум тус бүрийн тайланд дүгнэлт гаргасан. 2023 онд Баянжаргалан, Хулд сумын газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах ажилд шаардагдах төсвийг гарган ажлын даалгаврыг батлуулан тус сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад оруулах саналыг хүргүүлээд байна.



1. ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН НУТАГ ДЭВЭСЭРИЙН ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ТОДРУУЛАЛТ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ АЖИЛ ГҮЙЦЭГЖСЭН ТУХАЙ ТӨВН ГАШИВЧУУЛА

2022.12.04
Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын ЗДТГ-тай 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан 01 тоот гэрээний дагуу "Эрдэнэдалай сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил"-ыг ажлын даалгаврын хүрээнд 2022 оны 09 дугаар сарын 16 - аас 12 дугаар 15-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

1. Газар зүйн нэрийн суурин судалгаа

ГЗБЭЗЭГ-ийн мэдээллийн төв, орон зайн өгөгдлийн мэдээллийн сангаас Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын газар нутгийн нэрийн зураг /1980-1987 онуудад хийгдсэн/, түүний жагсаалт болон тус сумын нутаг дэвсгэрийн 1:100 000-ны масштабытай 27 нэрэмж буюу газар зүйн зураг, 1:25 000-ны масштабытай 104 нэрэмж буюу газар зүйн зурагууд болон Улсын Их Хурлын 2003 оны 42-р тогтоолоор батлагдсан, "Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь" 8.6 боть нөмөнд орсон газар зүйн нэрийн жагсаалтыг тус тус авч суурин судалгааг явуулсан.

Суурин судалгаагаар Улсын геодези, зураг зүйн газрын /хуучнаар/ хэргийн /1980-1987/ судалгааны үндсэн дээр хийгдсэн тус сумын газар зүйн нэрийг жагсаалт болон нэрийн зурагаар нэгтгэн үзэхэд нийт 763 газар зүйн нэр хэргийн судалгаагаар тодруулан тогтоосон байна. Харин УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолоор тус сумын 637 газар зүйн нэр батлагдсан байна.

1980-1987 онуудад хийгдсэн хэргийн судалгааны газар зүйн нэрээс дарауй 116 газар зүйн нэр УИХ-аар батлагдсангүй байна.

Мөн хэргийн тодруулалтад гаргахаас өмнө тодруулалтад сумын Газрын даамал, ЗДТГ, иргэд, малчидтай хамтран ажиллах, байршлаараа буруу болон зөрүүтэй тэмдэглэгдсэн газар зүйн нэрийг жагсаалтыг гаргасан ба тэдгээрийн газар

дээр нь өнж, байршлын зөрүүтэй газар зүйн нэрийг сонбиолцоуулах, засагдсан байршлаар мэдээллийн санд оруулах.



2. Газар зүйн нэрийн хэргийн тодруулалт

Эрдэнэдалай сумын газар зүйн нэрийн хэргийн тодруулалтын ажлыг гүйцэтгэхдээ ЗДТГ-ын даргатай хамтран Газар зүйн нэрийн салбар эмчлэлийн бүрэлдэхүүн болон ГЗН-ийн хэргийн тодруулалтаар багуудын нутаг дэвсгэрт ажиллах газарчин, 7 багийн дарга нар болон багийн ахмадуудын талаархи мэдээллийг авч, нээх маршарт ажлыг төгмөлдөөх зорготсон.

Хэргийн тодруулалтын ажлын хүрээнд хийгдэх ажлын талаар сумын Засаг дарга Б.Лхагвамандал, сумын ИТХ-ын дарга Н.Гансүх, Тамгын газрын дарга Г.Энэдэлгэр болон багийн дарга нарт танилцуулах, ажлын зохион байгуулалтын талаар хэлэлцэн эвлэлдэж, санал солигдсон.

Хэргийн тодруулалтад сумын 1-р баг буюу Цэвэр багийн Засаг дарга Д.Цогбадрах, 2-р баг буюу Өнгөт багийн дарга, 3-р баг буюу Тэнгэлэг багийн Засаг дарга М.Өсгиймаа, 4-р баг буюу Рашаант багийн дарга Мөнхбаатар, 5-р баг буюу Цагаан-Овоо багийн дарга Д.Ууганбаатар, 6-р баг буюу Сангийн Далай багийн дарга Ж.Өлзийжаргал, 7-р багийн дарга Ж.Төвшинбаатар болон ахмад настан, малчид Н.Гансүх, И.Дүрээ, Д.Бямбаа, Ч.Гүрээсэрэн, Балдандорж, Мянхга, Намсрайнооров, Дамдринжав зэрэг 20 гаруй хүн болон "Оюу амьсэг" ХОХ-ийн менежерүүд тус тус өрсөцөг, энэхүү ажлыг амжилттай гүйцэтгэлээ.

Аймгийн хэмжээнд 15 сумын 233 цэгийн 6908382.55 га бэлчээрийн талбайд 2022 оны 08 дугаар сарын эхний 10 хоногт багтаан хээрийн хэмжилт боловсруулалтын ажлыг зохион байгуулсан.



ГУРАВ. ДУТАГДАЛТАЙ ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Тус онд хэрэгжүүлэх арга хэмжээний 58 дугаар заалт болох Аймгийн хэмжээнд гадна инженерийн шугам сүлжээг улс, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн орон сууцны хороололд шинээр баригдах орон сууцны барилгын нийт талбайн 2,0 хувийг орон нутгийн өмчид шилжүүлэн авах замаар орон нутгийн өмчит түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт удааширсан тул түрээсийн орон сууцны сан бүрдээгүй байна.

Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хугацаа дууссан тус төлөвлөгөөг шинээр боловсруулж байна. Мөн тус аймаг дахь Төрийн аудитын газраас “Ундны усны чанар, аюулгүй байдал, хэрэгцээ, хангамжийн талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийгдэж 28 хувьтай үнэлэгдсэн бөгөөд цаашид өгсөн зөвлөмжийн дагуу ажлыг зохион байгуулан ажиллах шаардлагатай.

ДӨРӨВ: ГЭРЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг даргын гэрээгээр хүлээсэн үүргийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6.2.3.2-т заасны дагуу 98.1 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь яамнаас батлагдан ирдэг. Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу төлөвлөлтийн шаардлага хангахгүй шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшин нь тоон утгаар илэрхийлэгдээгүй байгаа учраас хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэлтэй байлаа.

Цаашид Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 3б хавсралтын дагуу оны эхэнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний

удирдлагын тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагыг ханган томьёолж, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон, суурь түвшин, хүрэх түвшинг бодитой тооцон төлөвлөж батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх шаардлагатай байна.

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга

Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын

албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн ахлах мэргэжилтэн

Э.Одончимэг